

ЖАГАР НУТГИЙН ТУХАЙ БОДОЛ

Б.Нямаа /Төр Засгийн Амралт
Үйлчилгээний Цогцолборын дарга/

Амьдралын хүлээсийг зад тийрч
Аяны харгуйг зоригтой дугтарч
Дэлхийн зулай цаст Хималайг
Дуулэн давж хийморио сэргээн
Далай багшийн өлтий бат оршсон
Дэлгэр баян Жагар нутагт очихсоон.

Бурхан багшийн мэндэлж таалсан
Байжалин балгасыг бишрэн үзээд
Маргадмандаа цөөрмийн ариун уснаас
Магнайдаа хүргэж сүслэн адислаад
Сац суварга түүх шашдирыг нь бишрээд
Саарнат хэмээх мөргөлийн газар нь саатахсаан.

Өнө эртний Энэтхэг соёл
Ведийн сударыг шимтэн сонирхоод
Өргөн олны тахил шүтээн
Ганжуур, Даанжуурын ботиудад мөргөөд
Бурхан багшийн адис тавьсан
Бодь модны нь сүүдэрт суухсаан.

Хорвоогийн хатууг хайлтал уянгалах
Хөгжим дууны нь аянд согтоод
Сувдан товчийг сэтэртэл бүжиглэх
Сайхан бүсгүйн харцанд аргамжуулаад
Түмэн өнгө солонгорон сүлэлдсэн
Түүхт нутаг Жагарт айлчлахсаан.

Асгарсан хайр цац болон сүндэрлэсэн
Ахин хийгдэхгүй Тажмахалыг үзээд
Амьд явсаны хэргийг бүтээж
Ариун Гангаас алгаараа амсаад
Хот балгад ой цэцэрлэгээр нь зугаалаад
Хосгүй соёлын өлгий Жагар нутагт очихсоон.

2007 оны I сар